



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 01-өдөр

Дугаар A/118

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Т

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны "Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай" 479 дүгээр тогтоол, 2023 оны "Журам, загвар батлах тухай" 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэх, нэгдсэн дугаар олгох, хянах, хадгалах журам"-ыг нэгдүгээр, "Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох бүртгэлийн дэвтрин загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмыг мөрдэж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр), Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар (Б.Батгэрэл)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 03 дугаар сарын 22 -ны өдрийн A/118 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГЭХ,
НЭГДСЭН ДУГААР ОЛГОХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсрол, шинжлэх ухааны яам /цаашид “яам” гэх/-ны Салбарын хяналт, Цэмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/-аас үйлдэх хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэх, дугаар олгох, хяналт тавих, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, архивд шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Хяналт шалгалтын баримт бичиг гэдэгт “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-д заасан баримт бичгууд хамаарна.

1.3. Улсын байцаагчийн үйлдсэн хяналт шалгалтын баримт бичиг нь нэгдсэн дугаартай байна.

Хоёр. Хяналт шалгалтын баримт бичгийг үйлдэх, хянах, бүртгэх

2.1. Баримт бичгийн нэр төрөл бүрээр ангилан оны эхнээс дараалуулан хяналт шалгалтын дугаар олгож, бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

2.2. Хяналт шалгалтын дугаар олгох, баримт бичгийг бүртгэх ажлыг зөрчлийн бүртгэл хариуцсан улсын ахлах байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/ хариуцан гүйцэтгэнэ.

2.3. Хяналт шалгалтын баримт бичигт улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан, нэгдсэн дугаар олгосноор тухайн баримт бичиг хүчин төгөлдөр болно.

2.4. Хяналт шалгалтыг хоёр ба түүнээс дээш улсын байцаагч хамтарч хийсэн тохиолдолд хяналт шалгалтын баримт бичигт улсын байцаагч тус бүр гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Хяналт шалгалтыг ахалсан улсын байцаагчийн дугаараар нэгдсэн дугаар олгоно.

2.5. Улсын байцаагч хяналт шалгалтын баримт бичгийг “Хяналт шалгалтын нийтлэг журам”, албан хэрэг хөтлөлтийн холбогдох хууль, журам, стандартад нийцүүлэн утга найруулга, уг үсгийн алдаагүй, монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу үйлдэнэ.

2.6. Улсын байцаагч нь нэгдсэн дугаар авсан баримт бичгийн нэг хувийг бүрэн бүрдэлтэйгээр хүлээнлгэж өгөх үүрэг хүлээнэ.

2.7. Улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулаагүй хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгохгүй.

2.8. Хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэж, нэгдсэн дугаар олгоходоо боловсруулсан албан хаагчаар “боловсруулсан” тухай тэмдэглэгээг бүрэн хийлгэнэ.

2.9. Боловсруулсан хяналт шалгалтын баримт бичгийг хянаж, танилцах албан тушаалтан түр эзгүй (ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, албан томилолттой) үед түүнийг орлож байгаа албан тушаалтан хянаж, гарын үсэг зурна.

2.10. Баталгаажуулсан хяналт шалгалтын баримт бичигтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг боловсруулсан болон хянаж, танилцаан гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан хариуцна.

2.11 Хяналт шалгалтын баримт бичигт дугаар олгохдоо байгууллагын Хууль, эрх зүйн хэлтэст хянуулсан байна.

Гурав. Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох, хадгалах

3.1. Хяналт шалгалтын баримт бичгийг дор дурдсаны дагуу бүртгэж, нэгдсэн дугаар олгоно:

3.1.1. албаны /БШУЯам/ дугаар - 03

3.1.2. нэгжийн дугаар – 00

3.1.3. Хяналтын дугаар:

3.1.3.1 Салбарын хяналтын газар – 00

3.1.3.2. Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар - 01

3.1.4. Улсын байцаагчийн хувийн дугаар – (000)

3.2. Салбарын хяналт, Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын баримт бичгийг дор дурдсаны дагуу бүртгэн, нэгдсэн дугаар олгоно:

3.2.1. Удирдамжид дугаар олгохдоо албаны дугаар, салбарын хяналтын чиглэлийн дугаар, бүртгэлийн нэгдсэн дугаарыг;

3.2.2. Танилцуулга, илтгэх хуудсанд тухайн удирдамжийн дугаарыг;

3.2.3. Удирдамжгүйгээр хийгдсэн хяналт шалгалтын танилцуулга, илтгэх хуудсанд албаны дугаар, нэгжийн дугаар, нэгдсэн дугаарыг;

(Жишээ нь: 03-00/01 гэсэн дугаар олгосон бол, (03) - албаны дугаар, (00) нэгжийн дугаар, (01) нь нэгдсэн дугаар гэж ойлгоно.)

3.2.4. Улсын байцаагчийн үйлдсэн акт, албан шаардлага, дүгнэлтэд улсын байцаагчийн хувийн дугаар болон нэгдсэн дугаарыг бичих;

3.2.5. Улсын байцаагч орон нутагт ажиллах явцад танилцуулга, илтгэх хуудаснаас бусад хяналт шалгалтын баримт бичгийг 2 хувь үйлдэн бичиг хэрэг хариуцсан мэргэжилтнээс олгосон дугаарыг бичиж, 1 хувийг шалгуулагчид, үлдсэн хувийг орон нутгаас ирснээс хойш ажлын 5 хоногт багтаан бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

3.3. Энэ журмын 2.1, 2.2-т зааснаас бусад хяналт шалгалтын баримт бичгийг дараах журмын дагуу бүртгэж, дугаар олгоно:

3.3.1. Салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгаварт албаны дугаар, салбарын хяналтын дугаар, бүртгэлийн нэгдсэн дугаарыг;

3.3.2. Салбарын улсын ерөнхий болон ахлах байцаагчийн шийдвэрт тухайн улсын байцаагчийн дугаар, бүртгэлийн нэгдсэн дугаарыг;

3.3.3. Шалгалтын тэмдэглэл, лац, ломбо тавьсан болон хөндсөн тухай тэмдэглэлийг бүртгэхдээ бичигдсэн баримтын өнгөн хувь дээрх хэвлэмэл дугаарыг бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ;

3.3.4. Мэдэгдэх хуудсыг хяналт шалгалтын удирдамжийн дугаараар дугаарлана.

3.4. Хяналт шалгалтын баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, хэрэг бүрдүүлэн байгууллагын архивд бүрэн бүрдэлтэй хүлээлгэн өгнө.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023
оны 03 дугаар сарын 00-ны өдрийн
A/118 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

1. Хяналт шалгалтын удирдамжийн бүртгэл

д/д	Он, сар, өдөр	Албаны дугаар, улсын байцаагчийн хувийн дугаар, нэгдсэн дугаар	Хаана, хэнд хандаж гаргасан	Товч утга	Хуудасны тоо	Хяналт шалгалтын баримт бичиг үйлдсэн улсын байцаагчийн овог, нэр	Хэвлэмэл хуудасны дугаар
0	1	2	3	4	5	6	7

2. Салбарын ерөнхий байцаагчийн албан даалгаврын бүртгэл

д/д	Он, сар, өдөр	Албаны дугаар, улсын байцаагчийн хувийн дугаар, нэгдсэн дугаар	Хаана, хэнд хандаж гаргасан	Товч утга	Хуудасны тоо	Хяналт шалгалтын баримт бичиг үйлдсэн улсын байцаагчийн овог, нэр	Хэвлэмэл хуудасны дугаар
0	1	2	3	4	5	6	7

3. Улсын /ахлах/ байцаагчийн актын бүртгэл

д/д	Он, сар, өдөр	Албаны дугаар, улсын байцаагчийн хувийн дугаар, нэгдсэн дугаар	Хаана, хэнд хандаж гаргасан	Товч утга	Хуудасны тоо	Хяналт шалгалтын баримт бичиг үйлдсэн улсын байцаагчийн овог, нэр	Хэвлэмэл хуудасны дугаар
0	1	2	3	4	5	6	7

4. Улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлагын бүртгэл

д/д	Он, сар, өдөр	Албаны дугаар, улсын байцаагчийн хувийн дугаар,	Хаана, хэнд хандаж гаргасан	Товч утга	Хуудасны тоо	Хяналт шалгалтын баримт бичиг үйлдсэн	Хэвлэмэл хуудасны дугаар
0	1	2	3	4	5	6	7

		нэгдсэн дугаар				улсын байцаагчийн овог, нэр	
0	1	2	3	4	5	6	7

5. Улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлтийн бүртгэл

д/д	Он, сар, өдөр	Албаны дугаар, улсын байцаагчийн хувийн дугаар, нэгдсэн дугаар	Хаана, хэнд хандаж гаргасан	Товч утга	Хуудасны тоо	Хяналт шалгалтын баримт бичиг үйлдсэн улсын байцаагчийн овог, нэр	Хэвлэмэл хуудасны дугаар
0	1	2	3	4	5	6	7

6. Улсын ахлах байцаагчийн шийдвэрийн бүртгэл

д/д	Он, сар, өдөр	Албаны дугаар, улсын байцаагчийн хувийн дугаар, нэгдсэн дугаар	Хаана, хэнд хандаж гаргасан	Товч утга	Хуудасны тоо	Хяналт шалгалтын баримт бичиг үйлдсэн улсын байцаагчийн овог, нэр	Хэвлэмэл хуудасны дугаар
0	1	2	3	4	5	6	7

7. Улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмжийн бүртгэл

д/д	Он, сар, өдөр	Албаны дугаар, улсын байцаагчийн хувийн дугаар, нэгдсэн дугаар	Хаана, хэнд хандаж гаргасан	Товч утга	Хуудасны тоо	Хяналт шалгалтын баримт бичиг үйлдсэн улсын байцаагчийн овог, нэр	Хэвлэмэл хуудасны дугаар
0	1	2	3	4	5	6	7

-----оо-----